



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Ажил зохион байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг хөрсөөр дарж булах, золбин нохой, муур устгах, устгасан нохой муурны сэг зэмийг шатаах, дарж булах, гэр хорооллын айл өрхийн нохойг бүртгэлжүүлэх үйл ажиллагаанууд болон дээрх ажлуудад хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 2018 оны ажлыг дүгнэх хурлын шийдвэрийг үндэслэн 2019 онд батлагдсан төсвийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй тус тус гэрээ байгуулсугай.

2. Гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Бүртгэлжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн нохойнд урьдчилан сэргийлэх үзлэг хийх, вакцин, туулганд хамруулах, үржлийг хязгаарлах ажлыг дүүргүүдийн мал эмнэлэг болон холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэхийг Нийслэлийн Мал эмнэлгийн газар /М.Адилбиш/-т, устгасан нохой, муурны сэг зэмийг бүртгэн авч, автопүүгээр жинлэж, бүртгэл хөтлөн зориулалтын зууханд шатаах, төвлөрсөн хогийн цэгт дарж булах ажлыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлэхийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т, дээрх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг хөндлөнгийн хяналтын төрийн бус байгууллагад тус тус даалгасугай.

4. Захиалагчийн хяналт тавьж ажилласан хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагын санхүүжилтыг ажил тус бүрийн батлагдсан төсвийн хоёр хувиар тооцож санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300173